



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Үндэсний давхар даатгал” ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 115,000,000.00 (нэг зуун арван таван сая) төгрөгийн балансын үнэ, 88,647,629.91 (наян найман сая зургаан зуун дөчин долоон мянга зургаан зуун хорин есөн төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Орхон-А33А” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэх Э.Ванчинхүү, “Орхон-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Батзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3.Автомашинь улсын дугаарыг шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



139961420



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн  
12... дугаар тогтоолын хавсралт

**"Үндэсний давхар даатгал" ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй "Орхон-Азза" ТӨХК-д  
балансаас балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Балансын үнэ(төгрөг/)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ниссан патрол маркийн 0129УБҮ улсын дугаартай, суудлын автомашин, JN1TANY62Z0000370	2011	1	115,000,000.00	88,647,629.91	26,352,370.09
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1 (нэг)</b>	<b>115,000,000.00 (нэг зуун арван таван сая)</b>	<b>88,647,629.91 (наян найман сая зургаан зуун дөчин долоон мянга зургаан зуун хорин есөн төгрөг ерэн нэгэн мөнгө)</b>	<b>26,352,370.09 (хорин зургаан сая гурван зуун тавин хоёр мянга гурван зуун далан төгрөг есөн мөнгө)</b>

-----00-----